

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ ЯВУУЛСАН СҮСЭГ БИШРЭЛИЙН
СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС**

Ц.Пүрэвсүрэн - Ховдын Их Сургууль, МУИС. НШУС. Философийн тэнхим, докторант

Түлхүүр үг: ертөнцийг үзэх үзэл, төлөвшилт, шашин, шашины баримжаалал, нийгэм-угсаатны үйл явц, шашины байгууллагууд, шашин уусах.

Товч утга: Оросын Хүмүүнлэгийн сан-Монголын БСШУЯ-ны шугамаар сүүлийн жилүүдэд судалгаа шинжилгээний хамтарсан төслүүд ХИС дээр амжилттай хэрэгжиж байна. Энэ ажлын хүрээнд "Монголын болон Оросын Алтайн ард түмний уламжлалт соёлд шашины шинэ хөдөлгөөнүүд болон дэлхийн сүсэг бишрэлийн нөлөөлөл" нэртэй хамтарсан төслийг хэрэгжүүлж байгаа болно. Төслийн судалгаа нь шашинлаг байдлын төвшин, шинж чанарыг илрүүлэх төдийгүй, орчин үеийн Монголын нийгэмд түүний илрэх хэлбэр, хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлоход чиглэгдсэн юм.

Хамтарсан төслийн судалгааны явцад олж авсан үр дүнгээс санал асуулгад оролцогчдын шашины баримжаалал, тэдний нас, боловсрол, жендерийн болон шашины байгууллагуудын зүгээс нийгмийн хүлээлт зэрэг асуудлыг энэхүү өгүүлэлд хөндлөө.

Дэлхий ертөнц нийгэм-улс төр хийгээд байгаль экологийн донсолгоо бүхий эгзэгтэй үеийг даван туулж байна. Энэ хүрээнд дэлхий нийтийн анхаарлыг үндэстэн хоорондын шашины харилцаа, посткоммунист улсуудад дэлгэрч буй шинэ шашины хөдөлгөөнүүдийн дэлгэрэлт болон эдгээрийн улс төр, нийгэм соёлын үр дагаварын асуудал эзэлж байна.

Өөрийн үндэсний соёлыг сэргээн мандуулах гэсэн далбаан доор угсаатны бүлэглэлүүд зөрчилдөх болж, харин шашины харилцаа өөрчлөлтийн үйл явцад татагдан орох боллоо. Монгол улс ч энэ үйл явцын гадна хоцорсонгүй. Төв Азийн өмнөх түүхэнд Нүүдэлчин Монгол улс гарамгай үүрэг гүйцэтгэсэн нь газарзүйч, түүхчид төдийгүй, шашин судлаачдын анхаарлыг ч зүй ёсоор татах цэг болж байна.

Ази тивийн хувьд шашины олон талт байдал бүрэлдэж буй өнөөгийн нөхцөлд хүн амын шашины хэрэглээ, нийгэм, төрийн зүгээс шашинд хандах хандлага, шашин хоорондын хурцадмал байдлын шалтгаан, хэлбэрүүд, шашины хүлээцтэй байдал, үндэстэн хоорондын харилцаанд шашины нөлөөлөл зэргийг судлан шинжлэх зорилго бүхий угсаатны шашины нөхцөл байдалд үнэлгээ хийх нь өндөр ач холбогдолтой юм. (Тишков В., 2004, с. 9).

Монгол улс 1990-ээд оноос эрх чөлөөт иргэний нийгмийг байгуулах зорилго тавьж энх тайван, тэгш эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн тэр дундаа иргэдийн шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөг үндсэн хуулиар нээлттэй болгож өгсөн нь хүний эрхийн хувьд томоохон ялалт дэвшил байсан. Гэвч үүнийг даган нийгэм соёлын орчинд шашины хэт олон урсгалууд хяналтгүй дэлгэрч байгаа нь үндэстэн хоорондын харилцаанд сөрөг нөлөөлөл үзүүлж болохыг үгүйсгэхгүй

төлөөлөгчидтэй зөрчил гардаг уу гэсэн асуултанд 42% (42) нь "тийм", 46% (46) нь "үгүй", 12% (12) нь "хариулахад хүндрэлтэй" гэж хариулсан нь шашин хоорондын зөрчил үүсэх магадлалтайг харуулж байна. Баян-Өлгий аймгийн оршин суугчдын саналаар зөрчлийн нэлээд хувийг ислам 17% (17), бөөгийн шашин 8% (8), буддизм 18% (18), католик 8% (8), үнэн алдартан 6% (6), протестант 4% (4) - ийг тус тус эзлэж байна. Шашин хоорондын харилцаа хурцдах боломж байгаа нь "Та ямар шалтгаанаар өөр газар шилжин суурьших болов?" гэдэг асуултанд үндэстэн хоорондын харилцааны асуудал 12%, 4% нь шашины шахалт хавчилт гэж хариулсан явдал юм. Иймэрхүү байдлаар шашин хоорондын харилцааны хөрсөнд сөрөг бүтцийн элементүүд хуримтлагдаж байж болох юм гэсэн үндэслэлийг онцлон тэмдэглэж байна.

Өдөр бүрийн түвшинд угсаатны шашины нөхцөл байдлыг тандах чухал үзүүлэлт нь асуулгад оролцогчдын өөр үндэстэнтэй гэр бүл болох явдалд хэрхэн хандах асуудал юм. "Гэр бүл болоход үндэстэн ямар ч хамааралгүй" гэж 48% (48), "Өөр үндэстнээс бүтсэн гэр бүлүүд үндэстэнг устгадаг" гэж 29% (29), "Ард түмнүүдийн хоорондох эв нэгдлийг бэхжүүлэхэд нөлөөлдөг" гэж 23% (23) хариулсан бол 89% (89) нь өөрсдийн хүүхдээ өөр шашины төлөөлөгчидтэй гэр бүл болохыг зөвшөөрөхгүй гэжээ.

Ази тивийн хувьд шашины олон талт байдал бүрэлдэж буй өнөөгийн шинэ нөхцөлд ислам шашины хүчин зүйл ихээхэн үүрэг гүйцэтгэж эхлэж байна (Зиновьев В.П., 2002; Курныкин О.Ю., 2002). Энэ бүс нутагт исламын сэргэн мандах үйл явц эрчимтэй явагдаж, мусульманы нийгмийн хөгжлийн бүхий л хүрээнд хүчтэй нөлөө үзүүлэх болов. Баян-Өлгий аймагт явуулсан судалгаанаас үзэхэд асуулганд оролцогчдын 60% (60) нь өөрсдийгээ казах үндэстэн, монголчуудын үндэсний шашин ямар шашин байх ёстой вэ гэсэн асуулгад бөөгийн шашин 26% (26), буддизм 48% (48), ислам 16% (16), тэнгэр шүтлэг 7% (7) гэжээ. "Ислам" гэдэг үг танд ямар төсөөлөл үзүүлдэг вэ?" гэсэн асуулгад 20% (20) нь терроризм, аль ч шашиныг хүлцэх 10%, бусад шашиныг гадуурхагчид 5%, шашины ухуулгыг дагах 23%, энх тайван дэг журам 51%, 41% нь исламийн засаглал тогтоох хэмээн хариулжээ. Судалгаагаар бусад шашины төлөөлөгчидтэй зөрчил үүсгэх магадлалын тухай асуултын 1, 2-рт (буддизм 18% (18), ислам 17% (17) нийт 35 хүн гэсэн үзүүлэлтээр буддизм болон ислам орж байна. Судалгаанд оролцогчдын 25% (25) нь исламын хийд нээх болон мусульманчуудын зүгээс өөрийн шашины зан үйл үйлдэх асуудалд сөрөг хариулт өгчээ.

Монгол улс дахь ардчилсан өөрчлөлтүүд, шашин шүтэх эрх чөлөөг тунхагласан зэрэг нь энэ бүс нутагт уламжлалт шашиныг сэргээхэд багагүй боломжийг нээж өгсөн төдийгүй, барууны хэрэглээний соёлын үнэт зүйлсийг авч явдаг христийн чиглэлүүдийг өөрийн оронд нэвтрүүлэх боломжийг олголоо.

Та протестант шашины чиглэлийн сүсэг бишрэлтэй хүнд яаж ханддаг бэ гэсэн асуулгад эерэг 3%, манай хотод энэ хүмүүс ямар ч өөрчлөлт хийж

чадахгүй 6%, тайван 23%, сөрөг 13%, 50% нь энэ ямар чиглэл болохыг би мэдэхгүй байна хэмээн хариулжээ. Эндээс харахад протестант чиглэлийг баримтлагчид өөрийн шүтлэгийг номлоход ямар нэг хүндрэл бэрхшээл эсвэл түүнийг хүлээж авах нийгэм соёлын орчин бүрэн бүрэлдээгүй байгаа юм. Мөн асуулгад оролцогчдын хариултаас үзэхэд шашины уламжлалт бус чиглэлүүд тус аймагт тархах үзэгдэл бага байгааг илэрхийлж байгаа төдийгүй энэ нь манай казак иргэдийн дунд үндэсний шашины (ислам) дархлаа харьцангуй тогтвортой хадгалагдаж буйг илтгэж байна. Харин яс үндэс болон ямар шашин шүтдэг бэ? гэсэн асуултуудыг харьцуулан үзэхэд казак иргэдийн дунд буддизм-1%, бөөгийн шашин-1%, урианхай иргэдийн 1% ислам шашин шүтдэг хэмээн хариулсан нь олон зуун жил зэрэгцэн оршин амьдарч ирсэн эдгээр хүмүүсийн дунд шашин уусах дүр зураг байж болох тул цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлага байна. “Хэрэв ойр төрлийн юмуу танил чинь протестант шашинтан болвол та хэрхэн хандах вэ?” гэсэн асуултанд 13% нь (13) үүнд ямар ч муу юм байхгүй, 11% (11) нь сөрөг байр суурь илэрхийлсэн бол 57% (57) нь энэ талаар хариулахад бэрхшээлтэй байна гэжээ. Асуулганд оролцогчдын хувьд протестантууд бол хөдөлмөрч 17% (17), ичгүүргүй 90% (90), овжин % (12), шашин шүтлэгтээ үнэнч 15% (15), эвийг хичээгч 7% (7), түрэмгий 7% (7), 4% (4) тэвчихийн аргагүй хүмүүс гэж үнэлжээ. Мөн энэ асуулгад 15% (15) нь бусад шашины төлөөлөгчдөөс амьдралын хэв маягаараа, шашины уламжлал нь 12% (12), ахуй амьдралдаа хатуу дэглэм баримталдаг 12% (12), оюуны чадвар 6% (6), үзэл суртлын болон улс төрийн чанаруудаараа 9% (9), 9% (9) нь зан суртахууны хувьд ялгаатай гэж тодорхойлжээ. Эдгээрийн үр дүнд протестант чиглэлийн (эсэргүүцэгч, буруушаагч) христийн номлогчид нэвтэрсэнтэй уялдсан өвөрмөц байдалтай шашины нөхцөл байдал үүсэн бүрэлдэж байна гэж ярьж болохоор байна. Барууны орнууд нь өөрсдийн шашины соёлыг дэлгэрүүлэх асар их туршлагатай, санхүүгийн хувьд хүчирхэгжсэн тэд монголчуудын дунд аажмаар шашинаа сурталчлан дэлгэрүүлэх нь түгээмэл болсоор байна. Асуулгын дүнгээс үзэхэд уламжлалт бус (үнэн алдартан, протестант г.м.) шашиныг өөрсдийн оршин буй газартаа байхыг сайшаахгүй боловч исламын сүм хийд нээх тухайд эерэг хариулт өгчээ.

Баян-Өлгий аймгийн иргэдийн олонхийн ухамсарт үндэстэн хоорондын харилцаанд шашины үүрэг өндөр түвшинд байна гэсэн төсөөллийг судалгааны материалууд харуулж байна гэж үзэж болохоор байна. Асуулганд оролцогчдын тодорхой хувь нь хүний амьдрал дахь шашины эзлэх байр суурийг онцолсон нь нийгмийн оюун ухаан – зан суртахууны хүрээнд түүний үүрэг чухал байгааг батлан харуулж байна. Шашинлаг байдлын шинж чанар, түвшинг тогтоосноор Монголын уламжлалт шүтлэг дэх шашинлаг байдлын гүнзгийрэлт, хүчтэй болох байдлыг урьдчилан тооцоолж болно. Шүтэгчдийн хангалттай дийлэнх хувь нь шашиныг сонгохдоо казакуудын ихэнхи нь исламыг, монголчуудын ихэнхи нь буддизмийг сонгосон явдал юм. Хэдийгээр шашины орон зай ижил бус,

шашины олон талт байдал байгаа ч өөрсдийн амьдралаараа чухамдаа ислам, буддизмд хамааралтай гэсэн нэгдмэл үндэстэй болохыг харж болно. Гэсэн хэдий ч протестант шашины байгууллагуудын шашины номлолын үйл ажиллагаа нь хүн амд нөлөөлөх, шинээр шүтэгчдийг өөртөө татах өрсөлдөөнт тэмцэлд орж болзошгүй байна. Шашины нөхцөл байдал доройтож байгаагийн өвөрмөц дохиог исламын хүчин зүйл харуулж байна. Судалгааны материалаас үзэхэд исламын хувьд шүтэгчдийнх нь ухамсарт сөрөг хандлагууд бүрэлдэх болжээ. Энэ нь явсаар үндэстэн хоорондын болон шашин хоорондын харилцаанд хурцадмал байдлыг үүсгэх магадлалтай байж болзошгүй. Шашины нөхцөл байдлын цаашдын өрнөлийг урьдчилан харах үүднээс энэхүү бүс нутаг дахь угсаатны шашины байдлын талаар олон нийтийн саналыг судлаж байх шаардлагатай байна.

РЕЗЮМЕ

Настоящая статья посвящена результатам исследования по социальному опрешению религиозных организаций, по религиозной тенденции, народов Баян-Улгийского аймака, и их возрасту образования по жендерному вопросу.

Итоги исследования показывают, что в сознании большинство народов занимает огромную роль религии в межнациональной коммуникации. Определённая часть участвующих в исследовании высоко оценивает роль религии в жизни человечества и она тоже считается важной в сфере социального менталитета и этики.

НОМ ЗҮЙ

1. Тишков В. Опыт этнологического мониторинга. М., 2004.
2. Зиновьев В.П. Угроза исламского экстремизма в Центральной Азии Россия – Центральная Азия: проблемы миграции и безопасности. Барнаул, 2002. с.47-53.
3. Бабаев М. Новые боги. Религия в киберпространстве: универсальный медиум. Газета НП, №6, 2002г.
4. Курныкин О.Ю. Исламский фактор в Казахстане: исторический опыт и современные реалии // Россия – Центральная Азия: проблемы миграции и безопасности. Барнаул, 2002. с.109-117